



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 4116

Улаанбаатар хот

**“Олон улсын сувилагчдын өдөр”-ийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай**

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/189 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ТУШААХ нь:

1. Олон улсын сувилагчийн өдрийг тохиолдуулан зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, бидний ирээдүйн сувилагч арга хэмжээний удирдамжийг хоёрдугаар, миний мэдэх сувилагч эссэ бичлэгийн уралдааны удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Олон улсын сувилагчийн өдрийг тохиолдуулан зохион байгуулахад шаардагдах зардлыг зохих төсвөөс гаргахыг нягтлан бодогч (Б.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийн хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг чанарын менежер (Д.Дашдэлэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 05 дүгээр сарын 06 -ны өдрийн
116 тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хамрах хүрээ	Хамтран ажиллах байгууллага	Хариуцах ажилтан
1.	Сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тушаал, төлөвлөгөөг боловсруулж батлуулах	5-р сарын 1			Г.Гантуяа О.Удвал
2.	"Бидний ирээдүй сувилагч" сэдэвт арга хэмжээг зохион байгуулах	5-р сарын 10	11,12-р ангийн сурагчид	Хангай цогцолбор сургууль	О.Удвал
3.	"Миний мэдэх сувилагч" эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулах	5-р сарын 13	11,12-р ангийн сурагчид	Хангай цогцолбор сургууль	Г.Гантуяа Д.Дашдэлэг
4.	Сувилахуйн тусламж үйлчилгээний түгээмэл үйлдлийн стандартын сургалтыг зохион байгуулах	5,6-р сар	ЭМТ-ийн ажилчид		Д.Дашдэлэг О.Удвал
5.	Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг иргэдэд зохион байгуулах.	5.6 сар	Иргэд		О.Удвал Ш.Номин
6.	Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээ арга хэмжээ зохион байгуулах.	5-р сарын 10	Хэвтрийн хүмүүс		О.Удвал
7.	Зохион байгуулсан ажлын тайланг зурган болон бичмэл хэлбэрээр НЭМГ-ын мэргэжилтэнд хүргүүлэх.	5 сарын 15			О.Удвал

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 05 дүгээр сарын 06 -ны өдрийн
416 тушаалын хоёрдугаар хавсралт



**ОЛОН УЛСЫН СУВИЛАГЧДЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
"БИДНИЙ ИРЭЭДҮЙН СУВИЛАГЧ " СЭДВИЙН ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Байгууллагын сувилахуйн хүний нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ерөнхий боловсролын төгсөх ангийн сурагчдийг хамруулах, төгсөөд сувилагчаар суралцах хүсэл эрмэлзийг нэмэгдүүлэх

Хоёр. Хугацаа

2024 оны 5 дугаар сарын 10-нд

Гурав. Зохион байгуулагч, хамтран ажиллах байгууллага

- Хангай цогцолбор сургууль

Дөрөв. Хамрагдах

- Ерөнхий боловсролын сургуулийн 11,12-р ангийн сурагчид


Тав. Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл

1. Сувилагч мэргэжлийг сурталчлах уулзалт ярилцлага хийх
2. Эрүүл мэндийн төвийн сувилахуйн тусламж үйлчилгээтэй танилцуулах

Зургаа. Хүлээгдэж буй үр дүн

Төгсөх ангийн сурагчдаас сувилагч мэргэжлээр суралцах сонголтыг нэмэгдүүлэх
Сувилагч мэргэжлийг сурталчлах ажлыг ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх ангийн сурагчдын дунд зохион байгуулна.

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 05 дүгээр сарын 06 -ны өдрийн
416 тушаалын гуравдугаар хавсралт



ОЛОН УЛСЫН СУВИЛАГЧ НАРЫН БАЯРЫГ УГТАН “МИНИЙ МЭДЭХ СУВИЛАГЧ” СЭДЭВТ ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

ЗОРИЛГО

Дүүргийн эрүүл мэндийн байгууллагын сувилахуйн хүний нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ерөнхий боловсролын төгсөх ангийн сурагчдийг хамруулах, төгсөөд сувилагчаар суралцах хүсэл эрмэлзийг нэмэгдүүлэх

ХАМРАХ ХҮРЭЭ

Багахангай дүүргийн нийт ерөнхий боловсролын сургуулийн 11,12 дугаар ангийн сурагчид

ХУГАЦАА

2024 оны 05 дугаар сарын 07-ноос 05 дугаар сарын 10-ны 17.00 цаг хүртэл хүлээн авна.

Шалгаруулалтыг 5-р сарын 13-ны өдөр хийж шагналыг гардуулна.

ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Эссэг А4 хэмжээтэй цаасан дээр 150-200 үгэнд багтаан гараар болон компьютероор шивж өөрийн боломжит аль ч хувилбарыг сонгож болно.
- Өгөгдсөн сэдвийн агуулга бүрэн байх
- Шивсэн тохиолдолд arial фондоор үсгийн хэмжээг 12-оор, мөр хоорондын зай 1,5-аар сонгож шивнэ
- Эргэн холбогдох утасны дугаар, нэр, хаягийг тодорхой бичих

ХҮЛЭЭН АВАХ

Эрүүл мэндийн төвийн Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан Г.Гантуяад цаасаар болон цахимаар хүлээлгэн өгнө. Утасны дугаар 88251080 ,
Цахим хаяг: bhemt.ub@gmail.com

ШАГНАЛ

Нэгдүгээр байр -1 Өргөмжлөл, мөнгөн шагнал
Хоёрдугаар байр—1 Өргөмжлөл мөнгөн шагнал
Гуравдугаар баяр-1 Өргөмжлөл мөнгөн шагнал